

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 10 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Нэг. Аймгийн ИТХ-ын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын бодлогын 6 хороод 10 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд ажиллаж ИТХ-ын Арвандөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудлуудад дүгнэлт гаргасан. Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 4 дүгээр хуралдаан 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж ИТХ-ын Арвандөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэх “Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024” аймгийн хэтийн зорилтын хэрэгжилтийн явцын тухай, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, Буддын шашны сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн хүсэлтийн тухай асуудлуудад хийсэн хороодын дүгнэлтийг хэлэлцсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Арвандөрөвдүгээр хуралдаан 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргав.

1. “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийн явцын тайлан, мэдээлэл, түүнд хурлын Хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд “Хөгжлийн түүчээ-Төв аймаг-2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилтын 4 бүлэг, 103 зорилт, 208 заалтыг аймаг, сумын түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил жилийн үндсэн чиглэл, салбаруудын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд 44 шалгуур үзүүлэлтийн явц 68.92 хувийн гүйцэтгэлтэй байх тул “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” гэж дүгнэв.

2. Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн хэтийн зорилт “Хөгжлийн Түүчээ-Төв аймаг”-2024, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Үндэсний хэмжээний хөтөлбөрүүд, дэд хөтөлбөрүүд, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол улсын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хүргүүлсэн саналтай уялдуулан боловсруулсан тул батлав.

3. Мөн аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын өргөн мэдүүлсэн 2020 оныг “Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарлах саналыг хэлэлцээд дэмжиж, тогтоол гаргасан.

4. Буддын шашны сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах тухай ирүүлсэн хүсэлтийн талаар аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн холбогдох баримт бичиг, түүнд Хурлын Нутгийн удирдлага, хууль хяналт, гадаад харилцааны хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Төв аймгийн Зуунмод сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлалтай “Өрнөн дэлгэрэх амирлан тэгчилэн” хийдэд буддын шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохыг дэмжив.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн XIV хуралдаан хуралдаж 10 асуудал хэлэлцэж 4 асуудлыг хурлын хороодод шилжүүлж, 2 тогтоол батлаж, хуралдааны 3 тэмдэглэлээр үүрэг өгсөн. Тэргүүлэгчдийн ээлжит бус V хуралдаанаар 6 асуудал хэлэлцэж хурлын хуралдаанд 3 асуудлыг шилжүүлж, 4 тогтоол батлав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт хамтран аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд, 27 сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг 2019 оны 10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд "Бодлого боловсруулалт, стратеги төлөвлөлт, төсөв санхүүгийн удирдлага" сэдэвт сургалтанд хамрууллаа.

Мөн "Тунгаамал төв" ТББ-тай хамтран 10 дугаар сарын 23-ны өдөр "Бодлогын бичиг баримтыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ хийхэд иргэдийг оролцоог сайжруулах" нь сэдэвт сургалтыг зохион байгуулж, 27 сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг хамруулсан.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 1 удаа хийж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлаас гадна 11 асуудал хэлэлцсэн.

Сум, орон нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажлын үр дүнг ахиулах зорилгоор аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад 27 сумыг хуваарилан хариуцуулж, “Сумын хөгжилд таны оролцоо” 2 сарын аяныг зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж буй 25 хэсгийн ахлагчийн судалгааг гаргалаа.

ТАЗ, Хүний нөөцийн академийн хамтран зохион байгуулсан “Хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит хийх нь уулзалт, хэлэлцүүлэг”-т 5 албан хаагчийг хамруулсан.

2020 оныг “Хүртээмжтэй, чанартай үйлчилгээний жил” болгон зарлах шийдвэр, төрийн албан хаагчдын зөвлөгөөнөөс гаргах зөвлөмжийн төслүүдийг боловсруулан батлуулсан.

2019 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн 38 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2019.10.28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, /Үүнээс ТАХ 2/ холбогдох яам, дээд шатны байгууллагад уламжлаад байна. Холбогдох яам, дээд шатны байгууллагаас дэмжсэн санал ирүүлсэн 3 иргэний материалыг /Үүнээс ТАХ 1/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.11.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 125 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 186 иргэнийг шагнаж, урамшууллаа.

Төв аймгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэлтийн 2019 оны 3 дугаар улирлын мэдээг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг дарга 594 иргэнийг өөрийн биеэр хүлээн авч уулзан санал, хүсэлт, гомдол, мэдээллийг сонсож холбогдох хуулийн тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн. Мөн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой буюу гачигдал тохиолдсон, дэмжлэг хүссэн 30 иргэнд 6.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгожээ.

2019 оны гуравдугаар улиралд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл:

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэл-тийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	15	15				100
2	Аймгийн ЗДТГ	288	161	95		32	88.89
3	Сумд	9563	8360	246	49	908	90.51
4	Харьяа агентлаг, хэлтэс	1625	1545	17	15	48	97.05
Нэгдсэн дүн		11491	10081	358	64	988	91.40

Үүнээс

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	15	14				1	
2	Аймгийн ЗДТГ	288	233	37		18		
3	Сумд	9563	8793			107	654	9
4	Харьяа агентлаг, хэлтэс	1625	1506		19	44	56	
Нэгдсэн дүн		11491	10546	37	19	169	711	9

Нийт 11491 өргөдлөөс хүсэлт 10825, гомдол 116, санал 550 байна. Үүнээс

1. Газартай холбоотой асуудлаар 3074 / 26.75%
2. Хүний нөөцтэй холбоотой асуудлаар 728 / 6.33%
3. Халамжийн үйлчилгээний чиглэлээр 1333 / 11.6%
4. Иргэний бүртгэлийн чиглэлээр 1013 / 8,81%
5. Нийгмийн даатгалын холбогдох асуудлаар 765 /6,65%

МУЗГ-аас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласан бөгөөд ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 3 дугаар улирлын байдлаар тооцож ЗГХЭГ-т хүргүүлэв. Төлөвлөгөөний биелэлт 71,87%-тай байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/80 дугаар захирамжаар батлагдсан “2019 оны нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тооцож, Засаг даргын Зөвлөлийн 19 дүгээр хурлаар хэлэлцүүлэв. Хэрэгжилтийг тоймловол:

№	Төлөвлөгөөний хавсралтын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц							
			Хэрэгжилт					Үн/боломжгүй	Гүйцэтгэлийн хувь	Оноо
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй /0-9%/				
						100% /90-100/	70% /50 - 89/			
1	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	92	85	2	2		1	2	96,66	4,83
2	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар сонсох асуудлын төлөвлөгөө	15	13	1	1				93,33	4,66
3	Сургалт, семинар, зөвлөгөөний төлөвлөгөө	65	52	6	2		5		87,38	4,37
4	Орон нутагт хийгдэх нээлттэй хаалганы өдөрлөгийн төлөвлөгөө	16	6	5	3		1	1	69,33	3,47
5	Орон нутаг, харьяа хэлтэс агентлагуудад хийгдэх хяналт-шинжилгээ үнэлгээ шалган туслах ажлын төлөвлөгөө	31	15	13	2		1		79,67	3,98
6	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах төлөвлөгөө	9	7				2		77,77	3,89
Дүн		228	178	27	10		10	3	88,84	4,44

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж 16 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцож байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдааныг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, 5 асуудал хэлэлцэн 2 тогтоол гаргасан.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолын дагуу аймгийн Салбар зөвлөлийн гишүүдийн брэлдэхүүнийг ТАЗ-ийн 2019 оны 100 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан.

Дунд болон богино хугацааны зорилтуудад тусгасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор “Мерит зарчимд суурилсан манлайлал” аймгийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн, “Төрийн байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Зуунмод хотноо зохион байгуулахад 521 албан хаагч хамрагдлаа. Зөвлөгөөний үеэр Төрийн албаны тухай хууль тогтоомжтой холбоотой 17 чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг, мэдээллээр хангаж, оролцогчдоос 35 асуулт 56 санал бичгээр гаргаж, Төрийн байгууллагад 8, Төрийн албан хаагчдад хандсан 4 чиглэлээр зөвлөмж боловсруулан батлууллаа.

Мөн Төв аймгийн Төрийн албан хаагчдын бусдаас ялгарах “Гал голомт” хүндэтгэлийн бэлгэдлийг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Б.Цэрэндаваад гардуулж, хүндэтгэлийн өргөөнд залав.

Төрийн байгууллагын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох зөвлөмж, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, Газар эзэмших, ашиглах эрхийн баталгаажуулалт, бүртгэлжүүлэлт, барьцаа лавлагаа, Кадастрын зургаар үйлчлэх, Газар өмчлөх эрхийн лавлагаа, Дахин төлөвлөлтийн талаар танилцуулга мэдээлэл, Үйлчилгээний төлбөр хураах, Засвар үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт хүлээн авах, Цахилгааны төлбөр тооцоо хийх, Цусны даралт, Биеийн жингийн индекс, Хэвлийн ЭХО, Музейн үзмэр үзэх, тэтгэвэрт гарах иргэдийн хөдөлмөрийн дэвтэр болон нийгмийн даатгалын дэвтэрт нягтлан зөвлөн туслах, Тэтгэвэр тэтгэмжийн сунгалт, Иргэдэд лавлагаа үйлчилгээ, Иргэний үнэмлэх дахин авалтын бүртгэл, захиалга хүлээн авах, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Эд хөрөнгийн мэдүүлэг хүлээн авах, гарсан гэрчилгээ олгох, Жолооны эрх сэргээх, хугацаа дууссан үнэмлэх солиулах иргэдэд зөвлөгөө өгөх, Шинээр ажилд орохыг хүссэн иргэдийг бүртгэх зэрэг 26 байгууллагын 83 төрлийн үйлчилгээг газар дээрээс нь иргэдэд шууд үзүүлэв.

ТАЗСЗ-өөс 2 жил тутам зохион байгуулдаг Төрийн албан хаагчдын урлагийн 2 дугаар их наадмын бүсийн шалгаруулалтууд зохион байгуулагдаж байна. II дугаар шатны шалгаруулалт: 2019.10.25-нд Эрдэнэ суманд Баян, Баянжаргалан, Эрдэнэ, Мөнгөнморьт, Архуст, Баяндэлгэр; 2019.10.28-нд Зуунмод суманд Алтанбулаг, Аргалант, Баянцагаан, Баян-өнжүүл, Сэргэлэн, Зуунмод сум; 2019.10.29-нд аймгийн ЗДТГазар, түүний харьяа хэлтэс агентлагууд; 2019.10.30-нд Жаргалант суманд Жаргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Сүмбэр, Борнуур; 2019.10.31-нд Өндөрширээт суманд Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант, Угтаалцайдам, Заамар, Цээл, Баянхангай, Өндөрширээт, Лүн сумдад тус тус бүсчлэн зохион байгуулагдаж байна.

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.10.30-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	25
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	4
3	Бүрэлдэхүүн	-

4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		30

2019 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй
1	Албан бичиг	206	36	36	
2	Өргөдөл, гомдол	31	31	31	

Гадаад харилцаа: 60 жилийн өмнө тогтоосон Польш-Монголын найрамдалын Цацралт нэгдэл одоогийн Баян сум, БНПУ-ын Глиноецк хотын харилцааг сэргээх зорилгоор аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэл тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 10 дугаар сарын 24-31-ний өдрүүдэд Польш улсын Глиноецк хотод ажиллав. Айлчлалын хүрээнд Бүгд Найрамдах Польш улсын Гадаад харилцааны Дэд сайд, Элчин сайд Бойко, Глиноецк хотын дарга Лукаш Капченский зэрэг албаны хүмүүстэй уулзаж, Баян сумын Засаг дарга Ц.Энхбаатар, Польш улсын Глиноецк хотын дарга Н.Капченский нар хамтын ажиллагаагааны санамж бичигт гарын үсэг зурав.

БНСУ-ын Пёнтект хоттой манай аймаг шинээр харилцаа тогтоон ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Нийтийн номын сангийн шинэчлэл засварт зориулж 400.0 сая вонны хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсний дагуу 2 тал хөтөлбөрийг хамтран боловсруулж байна.

Зуунмод сумтай харилцаа, хамтын ажиллагаатай ажилладаг Япон улсын Тоттори мужийн Ничинам сумын 60 жилийн ойн арга хэмжээ 2019 оны 10 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд болж, сумын Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын ХХААБ, МУЗГ хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл, Эрдэнэ сумын “Эрдэнэ МСҮТ”-ийн хооронд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд шинээр байгуулж буй “Мах махан бүтээгдхүүн боловсруулах” цехийн нээлтэнд оролцох төлөөлөгчид аймгийн ЗДТГ-т зочилж, аймгийн Засаг дарга болон холбогдох хүмүүстэй уулзав.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-н зохицуулагч Seungwoo Shin, орчуулагчийн хамт тухайн байгууллагын хэрэгцээ шаардлага, ажиллах нөхцөл зэргийг судлах зорилгоор аймгийн Музейд ажиллав.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 10 дугаар сарын байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300 гаруй төрлийн үйлчилгээг 7500 гаруй иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад **33**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **64** мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **5-н** дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давхардсан тоогоор **36** мэдээ мэдээллийг бэлтгэн давхардсан тоогоор **108** удаа иргэд, олон нийтэд хүргэлээ.

7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 13 гомдол санал, 1 талархал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: ХНХЯ, МХЕГ-ын хамтарсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийн удирдамжийн дагуу Баян, Сэргэлэн, Баянцагаан, Жаргалант, Баянчандмань сумдын уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явууж буй ААНБ-дад явуулж, судалгаа хийн илэрсэн зөрчлийг арилгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.

Геологи, уул уурхайн хяналтаар: Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн явц, ил уурхайн аюулгүй ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, улсын байцаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлээгүй 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 500 нэгжийн торгуулийн арга хэмжээ авсан. 16 аж ахуйн нэгжид нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, ил уурхайн аюулгүй ажиллагаа хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

“Дархан-Уул” чиглэлийн авто замын Төв аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй чиглэлийн ажлын ерөнхий гүйцэтгэгч байгууллагад хяналт шалгалт явуулж, 2, 3 дугаар багцын гүйцэтгэгчид нийт 16 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг тооцож байна. Төв аймгийн Баянчандмань сумын нутагт 4, Борнуур сумын нутагт 5, Жаргалант сумын нутагт 3, нийт 12 карьер ашиглаж байна. Эдгээр карьераас Засгийн газрын тогтоолд 8 карьер нь орсон бөгөөд хайрганы тухайн 12 карьерыг ашиглах тухай аймаг, сумын Засаг даргаас зөвшөөрөл аваагүй, гэрээ байгуулаагүй байна. Борнуур суманд зөвшөөрөлгүй худаг гаргасан, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт гаргуулаагүй, гэрээ хийгээгүй, ажилчдын хотхоны газрыг ашилах, эзэмших талаар холбогдох байгууллагаас зөвшөөрөл аваагүй зөрчилтэй байна.

Мөн Улаанбаатар хоттой залгаа байгаа мал төхөөрөх, мал нядалгааны үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх үүрэг даалгаврын хүрээнд Алтанбулаг, Эрдэнэсант, Сэргэлэн сумдад мал нядалгааны цех, Аргалант, Эрдэнэ, Зуунмод, Баяндэлгэр сумдын махны үйлдвэр ажиллаж байна.

Төлөвлөгөөт бус шалгалт: Иргэний ирүүлсэн гомдол, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/28 тоот удирдамжийн дагуу Баян сумын “Болор” зоогийн газар, Баянчандмань сумын зам дагуух 6 хоол, цайны газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 87 заалттай, 7 албан шаардлага хүргүүлэн, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан Баянчандмань сумын “Пицца чикен”, “Мичид зоог” цайны газруудын үйл ажиллагааг түр зогсоогоод байна.

Эм био бэлдмэлийн хяналтын чиглэлээр: Баян суманд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналтыг хийхэд “Чулуун солонго” эмийн сан эм барих зөвшөөрөлгүй этгээдээр эм худалдан борлуулсан, “Өлзий дарь” эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан зөрчлүүдийг илрүүлэн үйл ажиллагааг зогсоож, тус бүр 300 нэгжээр торгох шийтгэл ногдуулсан.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр: Олон нийтийн сүлжээгээр дурьдагдсан Төв аймгийн Баянчандмань, Борнуур сумын ногооноос авсан дээжинд хорт бодис агуулагдсан байна гэсэн мэдээллийн мөрөөр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторит ил талбай болон хүлэмжинд тариалсан төмс, хүнсний ногооны Баянчандмань сумын 5 дээж, Борнуур сумын 5 дээжид шинжилгээ хийхэд одоогийн байдлаар пестицидийн үлдэгдэл илрээгүй байна. Мөн 2019 оны тариалах үрийн материал, 2019 оны намрын ургацнаас нийт 17 нэр төрлийн 95 төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний дээжинд ургамлын өвчин, хортон шавж, пестицид, нитрат, нитритийн агууламж тодорхойлсон байна.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр: Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд урьдчилан сэргийлэх хяналт хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр: Барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй “МАК” ХХК, “Мөнхийн баянгал” ХХК, “Талс технологи” ХХК, “Энгүүн оргил” ХХК, “Лэл металл” ХХК-ууд болон аймгийн Нэгдсэн эмнэлэг, ОБГ, Авто засварын газруудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь: Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 122 сорьцыг шалгаж, 526 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулж, хугацаа хэтрүүлэхгүй олгов. Үүнээс 4 сорьц 4 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд: Монгол Улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын 2019 онд хийсэн бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Дэлгэрхаан суманд “Команд штабын сургууль”-ийг зохион байгууллаа.

Орон нутгийн иргэдэд хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчноо гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг энгийн ойлгомжтой, оролцооны арга зүйг ашиглан түгээн дэлгэрүүлэх, цаашид аймгийн 27 сумын иргэд хүн амыг сургаж дадлагажуулах, мэдлэг чадвар, дадал олгох зорилгоор тус сургалтыг зохион байгууллаа.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2009 оны 64/200 дугаар шийдвэрийн дагуу “Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдөр”-ийг “Төгс бүтээцгээ” уриан дор иргэд олон нийтийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж дадлагажуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ач холбогдлыг хүүхэд залууст танин мэдүүлэх, мэдлэг олгох чиглэлээр тэмдэглэн өнгөрүүлсэн.

Хойд бүсийн төв Орхон аймагт зохион байгуулагдсан хойд бүсийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах ангийн гал унтраах автомашины жолооч нарын сургалтад Тус газраас 8 алба хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ.

БНСУ-ын Гёнгги мужийн Галын академийн “Олон Улсын гал сөнөөгч, аврагчдын сургалт”-д Зуунмод сум дахь Эрэн хайх, аврах салбарын аврагч жолооч-холбоочин ахлах ахлагч Самдангийн Мөнхчулуун хамрагдаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн Гамшиг судлал магистрын хөтөлбөрт Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн ахмад Л.Нямдаваа, Салааны захирагч ахлах дэслэгч З.Билгүүн, Онцгой байдлын сургуульд Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн төгсөх 3 дугаар дамжаанд ГЭУҮДАХМэргэжилтэн дэслэгч П.Өлзийбаяр, Салааны захирагч дэслэгч Д.Бадамсамбуу нар суралцаж байна.

Онцгой байдлын газрын Ёс зүйн алба 10 дугаар сард 1 удаа хуралдаж сахилга ёс зүйн зөрчил гаргасан 4 алба хаагчийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлтийг газрын даргад уламжиллаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар: Зуунмод, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Лүн, Бүрэн, Өндөрширээт, Баян-Өнжүүл сумдын төрийн захиргааны байгууллага, сургууль, цэцэрлэг болон малчид, ард иргэдэд “Бэлэн бай”, “Хэн ч, Хэзээ ч, Хаана ч Бэлэн” дадлага сургалтыг зохион байгуулж, нийт 342 хүн хамрагдлаа.

“УБЦТС, ТӨХК-ны Зуунмод түгээх төв”, “Аржанчивлан рашаан сувилал ХХК”-ийн нийт 59 ажилчдад “Галын аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг осол, гал түймрийн үед хэрэгжүүлэх дадлага сургууль зохион байгуулах” чиглэлээр дадлага сургалтыг зохион байгуулсан.

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчид болон өсвөрийн аврагч клубын сурагчид хамтран Зуунмод сумын “Хүмүүн” ЕБС-ийн багш, сурагчдад “Аюулгүй амьдрах ухаан” сэдвийн хүрээнд гэнэтийн болзошгүй гамшиг осол, газар хөдлөлтийн үед хэрэгжүүлэх дадлага сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 19 бүлгийн 593 хүүхэд хамрагдаж гамшиг ослын үед өөрт байх материалыг хэрхэн зөв ашиглах тухай дадлага сургуулийг тайлбарлан үзүүллээ.

Зуунмод сумын гэр хорооллын айл өрхүүдэд Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан удирдамжийн дагуу “Өвөлжилтийн бэлтгэл” нэгдсэн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулж, хяналт шалгалт хийв. Тус шалгалтаар нийт 71 айл өрхийн 201 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа, заавар зөвлөмж өгч ажилласан.

Объектын гал түймэр: Төв аймгийн Зуунмод сумын Зүүндэлгэр баг, төв зам дагуу Налайхаас Улаанбаатар хотын чиглэлд явж байсан иргэн Б.Пүрэвсайханы 87-91 БНХ улсын дугаартай “Nissan Teana” загварын суудлын автомашин шатаж байна гэсэн дуудлагыг 2019.10.03-ны өдөр хүлээн авч, 6 албан хаагч, 1 автомашинтай ажилласнаар галыг бүрэн унтраасан.

Төв аймгийн Зуунмод сумын Ланс багийн “Сүм”-ийн 2-9 дүгээр гудамжны 417 тоотод оршин суугч иргэн Ө.Бямбацэдэнгийн гал гарч байна гэсэн дуудлагыг 2019.10.09-ний өдөр хүлээн авч, 6 алба хаагч, 1 автомашинтай ажилласан.

Төв аймгийн Баянжаргалан сумын Жаргалант багийн “Уушгийн” 3 дугаар гудамжны 54 тоотод иргэн А.Зоригтбаатарын хашаанд байсан 50 боодол өвс бүрэн шатаж дуусаад, 55 тоотод оршин суугч Г.Дүүрэнгийн 6x10 хэмжээтэй тоосгон 2 давхар байшин руу гал ороод 1 давхарын хэсэг шатаж байна гэсэн дуудлагыг 2019.10.22-ны өдөр хүлээн авч, орон нутгийн 100 хүн, 3 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж галыг бүрэн унтраасан.

Эрэн хайх ажиллагаа: Төв аймгийн Дэлгэрхаан сумын “Тэмээтийн ам” гэх газар найрнаас буцаж явсан иргэн Ш.Очирхуяг /38 настай, эмэгтэй/ 2019.10.11-ний өдрийн 17:30 цагт алга болсон дуудлагыг хүлээн авч, сумын ЗДТГ-ын 5 алба хаагч, Цагдаагийн байгууллагын 1 алба хаагч, 1 техник хэрэгсэлтэйгээр эрэн хайх ажиллагааг явуулж, 2019.10.12-ны өдрийн 00:31 цагт эсэн мэнд олж, эмнэлгийн байгууллагад хүлээлгэж өгсөн.

Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо Алтан тариа 3 дугаар гудамж 22А тоотод оршин суух иргэн Ж.Олзбат /46 настай, эрэгтэй/ Төв аймгийн Эрдэнэ сумын Өгөөмөр багийн “Хүннү тур” амралтын газраас 2019.10.02-ны өдөр гарч сураггүй алга болсон дуудлагыг 2019.10.23-ны өдөр авч, аймгийн ОБГ-ын 5 алба хаагч, Цагдаагийн газрын 6 алба хаагч, ар гэрээс нь 15 иргэн, орон нутгаас 3 алба хаагч нийт 29 хүн 7 автомашинтай эрлийн ажиллагааг эхлүүлж ар гэрийн хүсэлтээр эрлийн ажиллагааг зогсоосон.

Ой хээрийн түймэр: Төв аймгийн Борнуур сумын Бичигт багийн “Шар хоолой” гэдэг газар хээрийн түймэр гарсан тухай дуудлагыг 2019.10.18-ны өдөр хүлээн авч, нийт 87 алба хаагч, 12 автомашин, 1 трактор, 8 мотоциклтой ажиллаж түймрийг бүрэн унтраасан.

Техникийн холбогдолтой осол: Төв аймгийн Баянхангай сумаас Заамар сум орох шороон зам дээр 0222 УНБ улсын дугаартай “Prado” загварын автомашин, 2761 УНЦ улсын дугаартай “Accent” загварын автомашинууд хоорондоо мөргөлдөж “Accent” загварын автомашинд зорчиж явсан 2 том хүн, 1 хүүхэд хавчуулагдаж нас барсан дуудлагыг 2019.10.06-ны өдөр хүлээж авч, ажиллагаа явуулснаар холбогдох хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

МУЗГ-ын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдэд эрх зүйн мэдээллийг хүргэх, мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг сайжруулах зорилгоор “Эрх зүйн хөтөчийн ажиллах журам-ыг сум, байгууллагуудад хүргүүлж, үүрэг чиглэл өгөв.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын-“Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 10 сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэсэн.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 49 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, хууль, эрх зүйн асуудлаар нийт 96 иргэн, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 24 мэдээлэл оруулав.

Улсын хэмжээнд “Өсвөрийн сэргийлэгч-2019” тэмцээнд Лүн сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн “Хатуу самар” баг оролцож, 21 аймаг, 9 дүүргээс 2 дугаар шатны тэмцээнээс шалгарч, 3 дугаар шатны тэмцээнд оролцож 2 байр эзэлсэн.

Орхон аймагт 2019 оны 10 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулсан ХНХЯ-ны “Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын хүний нөөцийг чадавхжуулах” сэдэвт сургалтад аймгаас 5 албан хаагч хамрагдаж, сургагч багш болсон.

Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн 27 сумын хэмжээнд “Бүс-2019” Нэгдсэн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн 2 үе шаттайгаар зохион байгуулж байна.

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 21-нд Угтаалцайдам суманд, 10 дугаар сарын 23-нд Борнуур суманд “**Хамтарсан өдөрлөг**”-ийг зохион байгуулахад 215 иргэн оролцсоноос 192 иргэнд хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцааг үзүүлэв.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хууль, хяналтын байгууллагуудын хамтарсан “**Нэгдсэн өдөрлөг**”-ийг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Лүн суманд зохион байгуулж 146 иргэнд үйлчиллээ.

Архивын үйлчилгээ: Борнуур, Лүн, Угтаалцайдам суманд зохион байгуулсан өдөрлөгийн үеэр нийт 105 иргэн үйлчлүүлснээс 76 иргэний хүсэлтийг хүлээн авч, газар дээр нь архивын лавлагааг 35 иргэнд, 153 архивын хуулбар хувь гаргаж, 67 сан хөмрөгийн 254 хадгаламжийн нэгжийг ашиглаж, 29 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Улаанбаатар хотын “Тэнгэр” дээд сургуультай хамтран 9 сум, 3 байгууллагын нийт 19 архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтныг мэргэшүүлэх 1 дүгээр улирлын сургалт амжилттай зохион байгуулсан.

Тайлант хугацаанд архивын эх баримтаас 184 иргэний хүсэлтээр 499 хуулбар хувь, 105 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 809.5 мян.төг-ийн орлого төсөвт төвлөрүүлэв. 2 хөмрөгийн 60 хадгаламжийн нэгжийн 9673 хүний нэр, 1441 заалт, тушаалын тоог мэдээллийг програмд оруулж, өгөгдлийн сантай холбон цахим бааз үүсгэсэн. 2 хөмрөгийн 187 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн үйлчилгээ:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр: Тайлант хугацаанд цахим санд нийт 52,215 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9626, Газар өмчлөх эрхийн 42,589 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 23,718. Улсын төсөвт нийт 144,599,631 төгрөгийг орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 187 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 153 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 42, хууль хяналтын байгууллагад 38 лавлагаа мэдээлэл өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн 10.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулав.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн хэмжээнд энэ сард 671 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 нэгжээр буюу 6,7 хувиар өссөн, зөрчил 43944 бүртгэгдэж 10763 нэгжээр буюу 24,5 хувиар өссөн үзүүлэлттэй, гэмт хэргийн илрүүлэлт 39,6 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4,3 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 6,2%, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 15,9%, Залилал гэм хэрэг 35%, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 61,1%, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 29,8%-иар тус тус өсч, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 54,3%, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 25%, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 46,4%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах чиглэлээр Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Илрүүлэлт-шийдвэрлэлт-оргодол”, “Зэвсэг”, “Дураараа биш дүрмээрээ” аян, нэгдсэн арга хэмжээ, орон нутгийн хэмжээнд “Аз жаргалтай гэр бүл”, “Баар”, “Өвс” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

“Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ” аяны хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 10 сэдвээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 14 удаагийн сургалт сурталчилгаа, 4 өдөрлөг зохион байгуулахад 2424 иргэн хамрагдсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Иргэдэд ойрхон төрийн үйлчилгээ” өдөрлөгийг Төв аймгийн Зуунмод, Борнуур, Лүн, Угтаалцайдам суманд зохион байгууллаа. Нутаг дэвсгэрийн хэмжээнд малын хулгайн гэмт хэрэг өсөж байгаатай холбогдуулан “Илрүүлэлт”, “Оргодол”, “Шийдвэрлэлт”, “Зэвсэг” нэгдсэн арга хэмжээг сумдад зохион байгуулж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байранд эрүүлжүүлэгдсэн-25, баривчлагдсан-35, саатуулагдсан-5, нийт 65 хүнийг хүлээн авч ар гэр, асран хамгаалагчид 13 хүнийг хүлээлгэн өгсөн. Эрүүлжүүлэгдсэн 25 иргэний төлбөр 103750, хугацаа дуусаж суллагдсан 35 иргэний төлбөр 1432600, нийт 1536350 төгрөгийг төрийн санд тушаалгаж ажиллав.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 46 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 16 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд бүртгэв. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 3851 жолоочийг 141.273.0 төгрөгөөр торголоо.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Энэ сард Криминалистикийн шинжилгээ-143, Нийт хийсэн магадлан шинжилгээ-179, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-511, гарын мөрийн санг баяжуулсан-112, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 728 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
10 дугаар сар	398	451	73	776	407	396	52.4
	3920610.2	4254733.4	1676584.2	6498759.4	1971827.8	4526931.6	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Монгол Улсын Ерөнхий сайд болон ХХААХҮЯ-ны ажлын хэсэг аймгийн ургац хураалтын ажлын явц, цаг үеийн ажилтай танилцаж, тариаланчдын санал хүсэлтийг хүлээн авсан.

ХХААХҮЯ-ны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сан, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан “Техник үйлчилгээний дундын төв”-ийг Баянцогт, Аргалант суманд байгуулахаар 93.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төмс, хүнсний ногооны 17 техникийг олгох ажлыг зохион байгуулав. Мөн тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 150 ширхэг

чацаргана модны суулгацыг 5 жилийн хугацаатайгаар олгосон. Үр тарианы комбайныг 10 хувийн урьдчилгаатай нөхцөлөөр Угтаалцайдам, Цээл сумдын 5-н аж ахуй нэгжид олгов.

Тариалангийн талбайг хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэхээр Жаргалант суманд 50 км, Борнуур суманд 7 км, нийт 57 км талбайг хашаажуулах материалыг тус сумдад нийлүүлсэн.

Ургац хураалт 10-р сарын 25-ны байдлаар:

- Үр тариа 58017 га-гаас 72519,0 тн буюу нэгжээс 12,5 цн, үүнээс буудай 52886 га-гаас 66949,0 тн нэгжээс 12,5 цн,

- Төмс 7792 га-гаас 104958,3 тн буюу нэгжээс 134,7 цн,

- Хүнсний ногоо 1069,2 га-гаас 14477,5 тн буюу 135,4 цн,

- Малын тэжээл 11185 га-гаас 41064 тн буюу нэгжээс 33,7 цн,

- Тосны ургамал 13583 га-гаас 5339 тн буюу нэгжээс 3,9 цн ургац тус тус хураан аваад байна.

Төмс, хүнсний ногооны ургац хураалтын ажил дуусч, үр тариа–86.5%, буудай–85.6%, тосны ургамал– 74.3%, тэжээл–91.2%-тай хураалт явагдаж байна.

Мал аж ахуй: Аймгийн хэмжээнд малчин, мал бүхий иргэд 99123 тн өвс, 14978.3 тн гар тэжээл, 41064 тн ногоон тэжээл бэлтгэн нөөцөлснөөр МАА-ын өвөлжилтийн бэлтгэл 91.1 хувьтай хангагдлаа.

Засгийн газрын тогтоолоор 2019 онд аймгийн аюулгүйн нөөцөд 3080 тн өвс, бэлтгэхээс 1734.9 тн өвс, 1450 тн тэжээл нөөцлөхөөс 536.5 тн тус тус бэлтгээд байна.

ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 49 худаг гаргахаас 40 худаг гарч, 25 худгийг сумдад нь хүлээлгэн өгөв.

Бэлчээрийн хортонтой тэмцэх ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 139.0 мянган га талбайд хийхээр төлөвлөж, 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр бэлтгэлийг хангалаа.

Аймгийн хэмжээнд Галшар, Буденный, Англи үүлдрийн адуу, Сэлэнгэ, КЦТ, хар тарлан, симменталь, монтбилльярд, алатау, хар, улаан ангус үүлдрийн үхэр, Алтанбулаг, Баяд үүлдрийн хонь, Өлгийн улаан, Говь гурван сайхан, Эрчмийн хар, Өнжүүл, Баяндэлгэр үүлдрийн ямаа үржүүлэгдэж байна.

“Мал солилцооны хөтөлбөр”- ийн дагуу 7 суманд 280 толгой хурган хуцыг сайжруулагчаар нийлүүлэх ажлын зохион байгууллаа.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: Жижиг дунд, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор:

- “Нэг сум нэг бүтээгдэхүүн” худалдааг 15 дахь жилдээ зохион байгуулсан. Энэ удаа 27 сумын 150 гаруй аж ахуй нэгж, байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд 300 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 210.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. 8 номинациар шилдэг бүтээгдэхүүн шалгаруулж, 6 иргэнд "Аймаг хөгжүүлэх сан"-аас тус бүр 10,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах “Эрхийн бичиг” гардуулав.

- “Төв аймагт үйлдвэрлэл” хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хотын Лавай худалдааны төвд, УБЦТСүлжээ ТӨҮКомпанитай хамтран компанийн ажлын байранд тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 50 гаруй үйлдвэрлэгчид оролцож 70.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулсан “Хувцасны худалдаа, зах зээлийн боломж” сургалтад 5 сумын оёдолчин, “Батбайгаль” үйлдвэрийн “Торт чимэглэх арга зүй” сургалтад 5 сумын 6 иргэн хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн.

Төв хангайн бүсийн “Аварга тогооч шалгаруулах” бүсийн тэмцээнд Цээл, Баянхангай, Баянчандмань, Зуунмод сумын 11 тогоочийг оролцуулж, 4 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлэв.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт” малын эрүүл мэнд төсөлтэй хамтран “Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэх” сургалт зохион байгуулж 43 мэргэжилтэн, МЭҮН-ийн 30 малын эмч хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/562 дугаар захирамжаар “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт”-ын ажлыг эхлүүлж, вакцинжуулалт 4,2%-тай, улсын төсвийн санхүүжилтээр үйлчилгээний хөлс 183,8 сая төгрөгийн олгууллаа.

Хээлтүүлэгч малын бруцеллёзын шинжилгээнд 27 сумын 25413 толгой малыг хамруулж 99,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний 91-н нэгжид бруцеллёз, боом, томуу, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд 125,4 сая төгрөг олгов.

Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ: 2019 онд аймгийн хэмжээнд улс, орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар нийт 85,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.

- ✓ 770 хүүхдийн 7 дотуур байр
- ✓ 6 соёл, спортын төвийн барилга
- ✓ 550 хүүхдийн 5 цэцэрлэг
- ✓ 2200 хүүхдийн 4 сургууль
- ✓ 10 ортой 1 ЭМТ-ийн барилга
- ✓ 12 оффис, контор, багийн төвийн барилга

Нийт 35 барилга шинээр баригдаж, 12 барилга их засварт хамрагдаж байна. Мөн 39 худаг шинээр гаргаж, 6 чиглэлийн 77 км автозам баригдаж эхэллээ.

Аймгийн хэмжээний хөрөнгө оруулалт, их засварын ажлуудын гүйцэтгэл 77,6%-тай байна.

- УХО-ын 2018-2019 онд шилжих 18 төсөл, арга хэмжээний 12 төсөл арга хэмжээ бүрэн дууссан. 5 барилга 80-95 хувийн гүйцэтгэлтэй нийт ажлын явц -96,9%-тай байна.
- УХО-ын 2019 онд эхэлсэн 23 ажлуудаас 5 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих бөгөөд ажлын явц-55,0%-тай байна. УХО-аар хэрэгжих нийт төсөл арга хэмжээ 70,0%-тай байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 43 төсөл, арга хэмжээ 85,4 хувийн гүйцэтгэлтэй.
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 13 төсөл, арга хэмжээнээс зам барилга, засварын ажлууд бүрэн дууссан ба засвар арчлалтын ажлын хугацаа болоогүй. Нийт арга хэмжээ 90,5%-ийн гүйцэтгэлтэй байна.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 13 төсөл, арга хэмжээ 91,7%-ийн гүйцэтгэлтэй.

Нийт 41601.4 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээнд тендер зарлахаас 61 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт 95 хувьтай байна.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Баяндэлгэр, Баянчандмань сумын нэгдсэн халаалтад холбогдох асуудлыг газар дээр шалгасан. Баяндэлгэр сумын хуучин дизель станцын 40 жил ашиглагдахгүй байгаа барилгыг “Арвайн илч” ХХК-нд 52.5 сая төгрөгөөр шилжүүлж, дээрх мөнгөнд дүйцүүлэн сумын төвийн гадна цэвэр ус хангамжийн системийн угсралтыг шинээр гүйцэтгэхтэй холбогдох баримтыг аймгийн ИТХ-д өргөн барьлаа. Баянчандмань сумын хөрөнгийн маргаантай хэсгийг үлдээж, зохих хэсгийг “Хит повер теч” ХХК-д гэрээгээр түр эзэмшүүлсэн.

Орон нутгийн өмчийн оролцоотой “ШОБ” ХХК-ийн бордооны цехийн барилгыг дуусгаж, тоног төхөөрөмжийг сууриулан ашиглалтанд оруулсан.

Хөрөнгийн дахин үнэлгээний архивын баримт дутуу ирүүлсэн 12 суманд чиглэл өгсөн.

МУЗГ-ын 2019 оны 351 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар хувьчлахаар шийдвэр нь гарсан 91 айлын орон сууцны материалыг иргэдээс авч байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Хууль хяналтын байгууллагуудтай хамтран “Дэлхийн чанарын өдөр” нэгдсэн өдөрлөгийг Лүн суманд зохион байгуулж, 140 гаруй иргэнд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол, “Хэмжилзүйн тухай хууль”, Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, Жижиглэн худалдааны газар түүний үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019 Стандартын талаар мэдээлэл сургалт хийв. Өдөрлөгт худалдаа, нийтийн хоол үйлдвэрлэлийн 20 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээнд анхдагч болон давтан үнэлгээ, магадлан хяналтад хийж, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний 14 цэгт тохирлын гэрчилгээ олгож, сумын Чанартай үйлчилгээгээр Лүн сумын иргэн Э.Баасансүрэн захиралтай “Мөнх Их Мандал” ХХК-ний “Мандал” ресторан хамт олныг шалгарууллаа.

Баталгаажуулалтын зөвлөлийн 16 дахь хурлаар худалдаа 10, нийтийн хоол 3, амралтын газар 1, нийт 14 иргэн, аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1 жилийн хугацаатай олголоо.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

"Дэлхийн цагаан таягтны өдөр" буюу Хараагүй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Харж баясахын жаргал” өдөрлөгийг 350 гаруй иргэдийн дунд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, бариа, сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, Харааны бэрхшээлтэй иргэдийн урлагийн тоглолтыг үнэ төлбөргүй үзүүллээ.

“Гэр төсөл”-ийн хүрээнд 27 сумын 81 өрхийг гэртэй болгохоос одоогийн байдлаар 11 сумын 33 өрхөд гэр гардуулан өгөв.

“Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин ойн нөхөрлөлийг хөгжүүлэх” сайн туршлагыг турших ажлын хүрээнд 2019.10.23-ны өдөр Борнуур суманд ойн нөхөрлөлүүд болон сумын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд зэрэг 50 хүнийг хамруулан уулзалт, ярилцлага зохион байгуулсан. Тус уулзалтаар 4 нөхөрлөлийн гишүүдтэй ярилцлага хийж холбогдох мэдээлэл цуглуулан, нөхөрлөлүүдийн бүтээлтэй танилцаж дүрсжүүлсэн.

Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Жаргалант суманд зохион байгуулж, багийн айл өрхөөр айлчлан иргэдтэй уулзалт хийж, боловсрол, хүүхдийн хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон нийгмийн халамжийн ганцаарчилсан зөвлөгөө үзүүлэх, зөврийн номын сан мөн Халдварт болон ХБӨ-ний эрт илрүүлэг үзлэг, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт давхардсан тоогоор нийт 870 иргэнд нийгмийн салбарын үйлчилгээг цогц байдлаар хүргэлээ.

“Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрийн хүрээнд сургуулийн удирдлага, дотуур байрны багш, тогооч, үйлчилгээний ажилчдын харилцаа хандлага, манлайллын чадавхыг сайжруулах зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Батсүмбэр суманд 27 сумын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, тогооч, үйлчилгээний ажилтан, Политехник коллеж, МСҮТ-ийн төлөөлөл нийт 192 албан хаагчийг хамруулан зөвлөгөөн зохион байгууллаа.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Монголын багш нарын өдрийг ЕБС-ийн сургалтын менежер, сургууль, цэцэрлэгийн багш нарыг хамруулан зохион

байгуулж 2019-2020 оны хичээлийн жилд дэвшүүлэх зорилго, зорилтоо тодорхойллоо. Баярын арга хэмжээний хүрээнд Засгийн газар, БСШУСЯ, аймгийн ИТХ, Засаг даргын болон бусад шагналаар нийт 66 багш ажилтнуудыг шагнаж урамшуулав. Мөн боловсролын салбарт 2-4 дэх жилдээ ажиллаж байгаа “Аймгийн залуу багш нарын зөвлөгөөн”-ийг 3 дахь жилдээ зохион байгуулахад нийт 123 залуу багш оролцлоо.

Архуст, Мөнгөнморьт сумдын сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах ажил хийж 28 багш, 434 суралцагч, 63 эцэг эх, сум орон нутгийн 2 удирдах ажилтантай хамтран ажиллаж, зөвлөгөө зөвлөмж өгөв.

Батсүмбэр суманд аймгийн 30 сургуулийн дотуур байрны багш, ажиллагсад удирдах ажилтан нарыг хамруулан “Дотуур байрны II зөвлөгөөн” зохион байгуулсан.

“Бүтээн байгуулалт-хөрөнгө оруулалт”-ын урианы жилийн хүрээнд Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдад улсын төсвийн 1 тэрбум 17 сая төгрөгийн өртөг бүхий соёл спортын төвийг шинээр ашиглалтад орууллаа.

Албан бус насан туршийн боловсролын төвийн үйлчилгээ: Насан туршийн боловсролын үндэсний төв, Улсын тэргүүний 63 дугаар сургууль, Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын Насан туршийн боловсрол төвийн багш нарын арга зүйн бүсчилсэн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 3 аймгийн нийт 55 багш оролцсон.

Театрын үйлчилгээ: 2019 оны 10-р сард 12 удаагийн арга хэмжээгээр нийт 4600 гаруй үзэгчдэд үйлчилсэн.

10-р сарын 17-нд Говьсүмбэр аймагт “Наран ургахуй” эмгэнэлт драмын жүжиг, “Сарьсан багваахайн домог” хүүхэлдэйн жүжгүүдийг тус тус тоглож нийт 500 гаруй үзэгчид үйлчилсэн.

10-р сарын 21-24-нд Заамар, Эрдэнэсант, Лүн сумдад урлагийн бригадаар үйлчилж, “Фэйсбүүк од” ЕБС-ийн сурагчдын оролцоот, өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн сургамжит драмын жүжиг, “Сарьсан багваахайн домог” хүүхэлдэйн жүжгүүдийг тоглож 750 хүүхэд багачуудад соёл урлагийн үйлчилгээг үзүүлсэн.

10-р сарын 28-29-нд Төв аймгийн Төрийн албан хаагчдын урлагийн 2 дугаар их наадмын бүсийн шалгаруулалтуудыг зохион байгуулж, 770 төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид болон иргэд үзэж сонирхсон.

Музейн үйлчилгээ: Төв аймгийн соёл урлагийн байгууллагуудтай хамтран 2019 оны 09 сарын 26-27-ны өдрүүдэд Баян, Баянжаргалан, Архуст, Баяндэлгэр сумдад соёл урлагийн үйл ажиллагаа сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үйл ажиллагааг хийх ажлын удирдамжийн дагуу зохион байгуулж нийт цэцэрлэгийн 23 хүүхэд, ЕБС-ийн 131 сурагч, 58 иргэнд үйл ажиллагааг танилцуулж, “Төв аймгийн музей”, “Соёлын биет бус өвөөс суралцъя”, “Халх Монголын Ар Утай Манзуширын хийд” зэрэг гарын авлагуудыг тарааж, “Төв нутгийн соёлын өвөөс” номыг танилцуулсан.

Сэнтпаул бага сургуультай хамтран “Тахийн эх нутгаар” аяллыг 2019 оны 10-р сарын 09-ний өдөр зохион байгуулж, нийт 35 хүүхэд хамруулан “Хустайн байгалийн цогцолборт” газарт аялуулсан.

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Байгалийн түүхийн музейтэй хамтран өв музейн түр үзэсгэлэнгийн танхимд “Дунд төрмөлийн эрин” үзэсгэлэнг дэглээ байна. Үзэсгэлэнд 19 дэсийн 27 ширхэг олдворууд дэглэгдэж байгаа бөгөөд 2020 оны 01 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд иргэдэд толилуулна.

Музейн үндсэн үйл ажиллагааны орлогоос 1350000 төгрөгийг зарцуулж, Манзушир дахь Музейн гадна орчинд зориулалтын хогийн сав хийж байршуулсан.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2019 оны 10-р сард 332-н байнгын уншигч, 1433 ирэгсэд, нийт 1765 уншигчдад 3501 ном олгож уншуулсан.

2019 оны 10 сард 1,209,400 төгрөгийн 90 ширхэг ном авч сан хөмрөгөө баяжуулсан. Нийтийн номын нь Өндөрширээт сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч зөөврийн номын сангийн үйлчилгээг 1 сарын хугацаатай 40 номоор хүргэсэн.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Шинэ нисэх онгоцны буудлын ажилчдын дундах уламжлалт тэмцээнийг 10-р сарын 05-06-нд зохион явуулж 113 тамирчин, Хүүхэд хөгжил төслийн багийн тэмцээнд Зуунмод сумын 6 багийн 120 иргэн хамрагдсан.

2019.10.11-12-ны өдрүүдэд Баяндэлгэр сумын спорт заалны нээлтийн ажиллагаанд зориулсан волейбол, сагсан бөмбөг, ахмадын софт волейбол гэсэн 3 төрлийн тэмцээн уралдааныг зохион явуулж, 198 тамирчин хамрууллаа.

Ахмад волейболчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 10-р сарын 19-20-ны өдрүүдэд Угтаалцайдам суманд 35-45, 46-аас дээш насны ангилалаар зохион явуулахад нийт 14 багийн 98 тамирчин оролцсон.

Зуунмод сумын 6-н багийн дунд “Хөдөлгөөн эрүүл мэнд” сэдэвт 5-н төрлийн тэмцээнийг зохион байгуулж, иргэдийн хийсэн гар урлал, бүтээлээр үзэсгэлэн гаргаж, харилцан туршлага солилцов.

Борнуур суманд “Хөдөлгөөн эрүүл мэнд” өдөрлөгийг 9-н сумын 11-н багийн дунд 4-н төрлийн тэмцээн хэлбэрээр амжилттай зохион байгуулж, 146 хүнийг хамруулсан.

Аймгийн Засаг Даргын нэрэмжит бие бялдрын сорилын уралдаан үзлэгийг 10-р сарын 25-нд хийхэд 13 сумын 115 хүн хамруулсан.

МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан өсвөр үеийн жү-до бөхийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож ХЦС-ийн сурагч 40 кг-ын жинд Ц.Лхамсүрэн хүрэл медаль хүртсэн. БНСУ-ын элчин сайдын нэрэмжит цомын төлөөх тэмцээн 10-р сарын 10-12-нд зохион байгуулагдаж 2 алт, 1 мөнгө 7 хүрэл медаль хүртсэн. Өсвөр үеийн Үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2019.10.10-13-нд Дундговь аймагт зохион байгуулагдаж багийн дүнгээр 9-р байрыг эзэллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Төв аймгийн бизнес эрхлэгч залуучуудыг нэгтгэх, бизнес эрхлэгч залуучуудын эдийн засаг, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй бодлого хөтөлбөрийг сайжруулах зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр “TUV+2030 БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЗАЛУУЧУУДЫН ФОРУМ”-ыг Зуунмод хотод зохион байгуулж, 120 бизнес эрхлэгч залуус оролцлоо. Форумын зохион байгуулагчид Зуунмод сумын бэлэгдэл болох буга, согоо 2 илийн хамт бэлчээрлэж буй барималыг Төв аймгийн Мөнгөнморьт сумын иргэн Д.Баатарзоригтоор урлуулан бүтээлгэж, Зуунмод сумын Төв цэцэрлэгт хүрээлэнд байршууллаа. Энэхүү бүтээлийн өртөг 10 сая төгрөгийг форумд оролцогчид, нутгийн зөвлөлийн гишүүдийн хандиваар бүрдүүллээ.

Олон Улсын “Охидын эрхийг хамгаалах” өдрийг угтан 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр "Цэцэгсийг сонсьё" уулзалт арга хэмжээг зохион байгуулахад Зуунмод сумын Хүмүүн цогцолбор ахлах сургууль, 4, 5-р сургуулийн Хүүхдийн оролцооны байгууллагын 65 сурагч оролцлоо. Арга хэмжээнд оролцсон охидоос гаргасан саналын дагуу Хүүхдийн эрхийн улсын байцаагч шалгалт хийж, 2019.10.11-ний өдрийн 03 дугаар албан шаардлагыг сургуулиудад хүргүүлсэн.

"Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын аян 10 дугаар сарын 04-ний өдөр амжилттай зохион байгуулдаж Зуунмод сумын ЕБС-ийн ахлах анги болон МСҮТ-ийн 480 оюутан, сурагчид хамрагдсан.

Уран уншлагын аймгийн аварга шалгаруулах "Уран жиргээ 2019" уралдаан 10 дугаар сарын 7-ны өдөр Зуунмод хотод зохион байгуулагдаж 21 сумын 81 хүүхэд оролцож авьяас, ур чадвараа сорин өрсөлдөж, ангилал тус бүрд тэргүүлсэн оролцогчид Улсын уралдаанд оролцох эрхээ гардан авлаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2019 оны 10-р сарын байдлаар 1921 иргэнд 3027.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1246 иргэнд 823.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1133 иргэнд 534.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 4050 ахмад настанд 402.5 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 422 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 160.5 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1599 эхэд 299.5 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Алдарт эхийн одонтой 9071 эхэд 1215.3 сая төгрөг, алдар цолтой 59 ахмад настанд 103.9 сая төгрөг, 5137 ахмад настанд 810.7 сая төгрөгийн насны хишгийг олголоо.

0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5788 эхэд 2294.0 сая төгрөгийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон 291 эх /эцэг/-д 249.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй хүүхдийн мөнгөний босго оноог хангасан 26406 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтад Батсүмбэр сумын 38 иргэнийг хамруулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд Зуунмод сумын 20 иргэнийг хамрууллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 51 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 107 ажил олгогч байгууллага, иргэн, 121 сул чөлөөтэй ажлын байранд зуучлагдан, 296 шинэ ажлын байрны мэдээллийг бүртгэсэн.

Ажлаас чөлөөлөгдөн ажилгүй болсон 24 иргэнийг бүртгэж, тодорхойлолтыг Нийгмийн даатгалын хэлтэст өгсөн. Түр ажлын байранд ажилласан 1800 гаруй иргэний мэдээллийг сумдаас авч бүртгэв. Сумдад гарч байгаа шинэ ажлын байрны мэдээллийг хянаж тодруулахаар Баянжаргалан, Борнуур, Баян сумдад ажиллаж 26 шинэ ажлын байрыг баталгаажууллаа.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 4 сумын 6 иргэн хамрагдаж 30000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гэрээг байгуулж, шинээр 8 ажлын байр үүссэнийг ХЗЗ-ийн мэдээллийн санд бүртгэсэн. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг Батсүмбэр сумын 27 иргэнд зохион байгуулж, GSAS сургалтын төвд 810,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Зуунмод сумын 6 иргэнтэй ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 10 сард 4 иргэний 1092,0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгосон. “Төв аймагт үйлдвэрлэв” барааны дэлгүүрт 600,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж, 17 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 3 сумын 40 иргэнтэй хамтран ажиллаж хөдөлмөрийн хөлс 8120,0 мянган төгрөгийг ХЭДСангаас олгосон.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэ, Эрдэнэсант, Мөнгөнморьт, Жаргалант, Борнуур сумдын 10 малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулж, 34000,0 мянган төгрөгийн 567 толгой малаар малжуулан санхүүжилтийг олгож, 15000,0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээгдэж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг ВЕСТ МЕТОД сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж 10 багийн 21 иргэнд эхний шатны сургалтыг зохион байгуулж, 7 баг хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд Мэргэжлийн болон давтан сургалтад Зуунмод, Бүрэн, Заамар, Эрдэнэ сумын ажилгүй ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй 36 иргэнд үсчин, гар утас засварчин, оёдолчин, тогооч, малын асаргаа, хүнд машин механизмын оператор, мах боловсруулах үйлдвэрийн ажилтны сургалтад хамруулсан.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, төрийн захиргааны салбарт үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээг үзүүлсэн 8 ахмад мэргэжилтэнд 2282,0 мянган төгрөгийн урамшуулал

олгосон. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг Зуунмод сумын 1 иргэнд үзүүлж 2500,0 мянган төгрөгийн гэрээг байгуулан ажиллаж байна.

ХАБЭА-н дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 21 ААН байгууллагад улсын үзлэг зохион байгуулж, тайланг ХНХЯ-нд хүргүүлэв.

ХНХЯ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу гадаадын иргэн ажиллуулж буй ААНБ-д “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хууль”-ийн хэрэгжилтийг шалгаж байна. Одоогийн байдлаар Тэнхун, Жин дай вэй, Мон вольфрам, Монгол агро ресайкл зэрэг байгууллагууд шалгагдаж байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа хуралдаж, нийт 239 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 30 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 192 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 15 иргэнийг цуцалж, 2 иргэнийг буцаасан байна.

Аймгийн хэмжээнд архивын лавлагаа 732, тодорхойлолт 254, нөхөн даатгалын лавлагаа 55, аймаг, дүүрэг хоорондын лавлагаа 75, нийт 1116 лавлагаагаар иргэд даатгуулагчдад үйлчилсэн.

Аймгийн хэмжээнд 13947 тэтгэвэр авагчдад 4.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

Нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхижуулах төвийн бүсийн сургалт 2019 оны 10 дугаар сарын 23-25-ны хооронд Дархан-Уул аймагт зохион байгуулахад хэлтсийн 44 албан хаагчдыг хамрууллаа.

ЭХМК нь 2019 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Заамар, Угтаалцайдам, Баянцогт, Баянхангай, Цээл зэрэг сумдыг хамруулан нүүдлийн хурал зохион байгууллаа. Энэ үеэр 5 сумын 62 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс хөдөлмөр чадвар алдалтын байдалд 40 иргэнд зохицуулалт хийж, 37 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг сунгасан.

Эрүүл мэндийн үйлчилгээ: “Тогтвортой хөгжлийн зорилттой дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг уялдуулах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн худалдан авах ажиллагааны үр дүнд нийлүүлэгдсэн 5 нэр төрлийн 11494040 төгрөгийн үнэ бүхий хэрэгслийн хуваарийг гарган, ЭМГ-ын даргын А/51 дүгээр тушаалаар баталгаажуулж, “Мари Стопс” ОУ-ын байгууллага, сум, өрхийн ЭМТ-үүдэд хүргүүлсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр ард иргэд, үйлчлүүлэгчдэд эрүүл хооллолтын зөвлөгөө өгөх кабинетийг тохижуулан нээлтээ хийв.

Аймгийн Засаг даргын нэрэмжит бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилын уралдаант үзлэгийг 10 дугаар сарын 03-ны өдөр БТСГ, ЭМГ хамтран зохион байгуулсан. Тэмцээнд 16 сумын 8-64 насны 195 хүн хамрагдлаа.

Баянчандмань сумын нутагт сувиллын үйл ажиллагаа эрхэлдэг “Мон аврагас” ХХК, “Эх булаг” сувиллыг 10 дугаар сарын 10-ны өдөр магадлан итгэмжлэлд хамруулсан.

Оросын Холбооны улсын Эрхүү хотын Анагаах ухааны улсын их сургуульд төрөлжсөн нарийн мэргэжлээр ЭМГ-ын 1 хэлтсийн дарга, АНЭ-ээс 1 их эмч, Заамар сумаас 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Баян-Өнжүүл сумаас 2 эмнэлгийн мэргэжилтэн, Угтаалцайдам сумаас 1 их эмч суралцаж, мэдрэл, дотор, сэргээн засах, дүрс оношилгоо, эх барих, сувилахуйн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн.

ЭМЯ-ны Ёс зүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнтэй ЭМГ-ын дэргэдэх Ёс зүйн салбар хороо, АНЭ-ийн Ёс зүйн хэсгийн хорооны ажилтай танилцаж, “Хангалттай” үнэлгээ авсан. “Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага” сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулж, нийт 209 ажилтныг хамрууллаа.

Улсын гуравдугаар төв эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран Зуунмод сумын 679 иргэнд урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн үзлэг оношилгоог үнэ төлбөргүй хийж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Сарын статистик мэдээнд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн хурлыг өргөтгөн цахим хэлбэрээр зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2019.10.24-ний Үүрэг даалгавар өгөх тухай 4 чиглэл бүхий 01/1978 дугаар албан тоотыг сумын Засаг дарга, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хүргэж, “Өрх бүрт хүрч үйлчилье” 1 сарын аяныг зарлаад байна.

Заамар, Баянцогт, Угтаалцайдам сумдад бүртгэгдсэн хүүхдийн эндэгдэл, Нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх хурал зохион байгуулж, ЭХЭМҮТөвийн Тандалт судалгааны албанд хүргүүлсэн.

“Дэлхийн гар угаах өдөр”-ийн хүрээнд ЕБС-ийн 6062 сурагч, СӨББ-ийн 1391 хүүхэд, МСҮТ-ийн 55 оюутанд зөв дадал эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн явцын мэдээллийг ажлын хэсгийн хурлаар танилцуулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

ХӨСҮТ-ээс товлолын болон томуугийн урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцины татан авалтыг хийж, томуугийн урьдчилан сэргийлэх вакцин 1750 хүн тун хүлээн авсан бөгөөд дархлаажуулалтын явц 92 хувьтай байна.

Дэвид Хорсмэн болон "Оюутолгой" уурхай дахь хамт олон аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн 2 өрөөг хүүхдэд ээлтэй байдлаар засварлан тохижуулж, нэн шаардлагатай шарлагын УВЧ аппарат, утлагын аппарат хандивласан.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: Орлогын төлөвлөгөө эхний 9 сарын өссөн дүнгээр орон нутаг 2982.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 4105.6 сая төгрөг төвлөрүүлж 137.7 хувьтай, 1123.2 сая төгрөгөөр буюу 37.7 хувиар давуулан биелүүлсэн. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 11608.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 14055.4 сая төгрөг төвлөрүүлж 121.1 хувьтай, 2446.6 сая төгрөгөөр буюу 21,1 хувиар давуулан биелүүлэв. 9 дүгээр сарын байдлаар 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 4012.8 сая төгрөгөөр биелж, 120.5 %-тай байна.

3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Жаргалант, Лүн, Мөнгөнморьт, Сэргэлэн, Цээл, Эрдэнэсант зэрэг 14 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Заамар, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ, Зуунмод зэрэг 11 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баянхангай, 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Архуст сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Сумдад эхний 09 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 53.916.841,5 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 24206,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 16547.7 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 7658.7 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 6.359.225,9 мянган төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 6.165.535,6 мянган төгрөг

-Өрхийн эмнэлэгт 193.690,3 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 397.407,5 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 288.085,7 мянган төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 20.614.099,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 11.173.603,3 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 8.019.925,7 мянган төгрөг

-ОНХСангуудад 1.420.570,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2019 оны 9-р сарын байдлаар сумд, болон төсөвт/байгууллагууд нийт 311.905,7 мянган төгрөгийн авлага, 502.603,5 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 93932,8 мянган төгрөг буюу 18.69 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 116061,5 мянган төгрөг буюу 23.09 хувь нь цалингийн өглөг, 80480,8 мянган төгрөг буюу 16.01 хувь нь НДШ-ийн өр, 13865,8 мянган төгрөг буюу 2.76 хувь нь гэрэл цахилгааны зардлын өгрлөг, 62868,7 мянган төгрөг буюу 12.51 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 135394,0 мянган төгрөг буюу 26.94 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

“Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагуудад нэврүүлэх нь” сургалт зохион байгуулж 110 төрийн албан хаагчдыг хамруулав.

“Иргэдийн оролцоог хөгжүүлэх замаар орон нутгийн тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар удирдлага зохион байгуулалтыг сайжруулах нь” сургалтыг бүсчлэн зохион байгуулсан.

Төв аймгийн ЗДТГ үйлчилгээндээ чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) нэвтрүүлж гэрчилгээгээ гардан авлаа.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Төв аймагт 2019 оны 2-р ээлжийн цэрэг татлагын ажлыг 10 дугаар сарын 01-ний өдрөөс 14-ний өдрүүдэд 13 суманд, цэрэг татлагын товчоогоор 10 дугаар сарын 16-нд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг дахин хийж анги салбарт хуваарилан Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн дамжингуудаар үзлэгт оруулж цэргийн албанд тэнцсэн иргэнийг баримт бичгийн хамтаар хүлээлгэн өгсөнөөр ЗХЖШ-аас ирүүлсэн хяналтын тоог 100% биелүүллээ.

Хугацаат цэргийн алба хаасан залууст ХХҮГ-тай хамтран сул ажлын байранд бүртгэх, гарааны бизнесийн талаар уулзалт хийж, ажлын байранд зуучилсан.

Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн буюу 26-27 настай иргэдийн судалгааг гаргаж мэдэгдэх хуудас тараан, мөнгөн төлбөрийн талаар гэрээ байгуулан ажилласан. Мөн мөнгөн төлбөр төлөх насны дээд хязгаарт хүрсэн ч ар гэрийн гачигдал болон эрүүл мэндийн шалтгаанаар тэнцэхгүй иргэдийн 25 гаруй өргөдөл холбогдох бичиг баримтыг хүлээн авч судалж байна.

УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Төв аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг баталж, аймгийн Засаг даргад гардуулж өгөх үйл ажиллагааг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав.